



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан аймгийн Цэцэн-Уул сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/179/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улиастай сум
2025 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

"Хаан соёмбо аудит" ХХК-ийн аудитор Р.Мядагмаа

Утас: 99201964

Цахим хаяг: myadagmaa99201964@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

ТӨБЗГ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81000 Улаанбаатар, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.17 № 118

Танай _____ ны 17 _____

ЦЭЦЭН-УУЛ СУМЫН
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Ж.НАРАНЖАРГАЛ-Д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэцэн-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цэцэн-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Цэцэн-Уул сумын Хүүхдийн цэцэрлэг Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар болон аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 7,150.0 мянган төгрөгийн бараа материал, 26,348.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэснээ данс бүртгэлд тусгажээ. Цэцэрлэгийн 3368 м.кв газрыг сургуулийн өмнөх боловсролын чиглэлээр 40 жилийн хугацаатай эзэмшихээр гэрчилгээжүүлэн бусад биет бус хөрөнгийн дансанд 6,736.0 мянган төгрөгөөр үнэлж бүртгэсэн бөгөөд 929 м.кв газрыг үнэлж бүртгэлд тусгаагүй байна.

Аудитын гол асуудал

Цэцэн-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар байгууллагын 929 м.кв газрыг үнэлж, бүртгэлд тусгаагүй, шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Цэцэн-Уул сумын Хүүхдийн цэцэрлэг нь тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 69 арга хэмжээ төлөвлөж, гүйцэтгэл 95 хувьтай хэрэгжсэн байна. Тус цэцэрлэг нь тайлант онд нийгмийн даатгалын байгууллагаас 354.6 мянган төгрөгийн,

эзэн холбогдогчгүй 120.8 мянган төгрөгийн, нийт 475.4 мянган төгрөгийн авлагатай, 756.0 мянган төгрөгийн өглөгтэй ажиллажээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР


Д. БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

SORT_ID/	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ	ДАНС
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	85,414,959.10	88,244,036.32	1
2	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛГАХ ХӨРӨНГӨ	37,386,846.14	31,226,505.93	31
8	Банкинд байгаа бэлэн мөнгө	37,386,846.14	31,226,505.93	312
9	Төгрөг	37,386,846.14	31,226,505.93	3121
10	Төрийн сангийн харилцах	37,386,846.14	31,226,505.93	31211
14	Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.00	-	31215
27	АВЛАГА	240,795.21	475,429.39	33
28	Ажиллагсадтай холбогдсон авлага	(0.00)	(0.00)	33100
32	НДЦ-ийн авлага	-	354,634.39	33401
33	ХАОАТ-ын авлага	120,000.21	(0.00)	33402
35	Бусад зардлын тооцооны авлага	120,795.00	120,795.00	33404
36	Бусад авлага	(0.00)	(0.00)	
37	Байгууллагаас авах авлага	(0.00)	(0.00)	3351
59	БАРАА МАТЕРИАЛ	47,787,317.75	56,542,101.00	35
60	Түүхий эд материал	7,258,500.00	8,737,000.00	351
61	Тусгай зориулалттай материал	6,158,600.00	7,688,600.00	35110
62	Эм боох материал	1,099,900.00	1,048,400.00	35130
65	Хангамжийн материал	40,528,817.75	47,805,101.00	354
66	Бичиг хэргийн материал	1,378,460.00	1,949,660.00	35410
67	Аж ахуйн материал	3,718,400.00	5,454,410.00	35420
70	Барилгын засварын материал	2,242,000.00	1,828,000.00	35450
71	Хүнсний материал	9,974,526.75	7,872,100.00	35460
72	Бусад хангамжийн материал	23,215,431.00	30,700,931.00	35470
85	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,770,432,897.79	1,770,443,881.67	2
105	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,770,432,897.79	1,770,443,881.67	39
107	Биег хөрөнгө	1,762,086,897.95	1,762,097,881.83	392
108	Барилга, байгууламж	1,764,956,412.23	1,764,956,412.23	39201
109	Хуримтлагдсан элэгдэл	(49,488,690.84)	(65,416,202.40)	39202
112	Машин, тоног төхөөрөмж	45,133,579.92	61,182,059.92	39205
113	Хуримтлагдсан элэгдэл	(25,024,187.74)	(31,181,296.38)	39206
114	Тавилга, аж ахуйн эд хогшил	52,319,445.22	63,219,445.22	39207
115	Хуримтлагдсан элэгдэл	(28,006,668.85)	(32,859,544.77)	39208
121	Бусад үндсэн хөрөнгө	2,639,910.12	2,639,910.12	39214
122	Хуримтлагдсан элэгдэл	(2,639,910.12)	(2,639,910.12)	39215
124	Номын фонд	2,197,008.01	2,197,008.01	39217
125	Биег бус хөрөнгө	8,345,999.84	8,345,999.84	393
126	Програм хангамж	1,850,000.00	1,850,000.00	39301
127	Хасагдуулга	(240,000.16)	(240,000.16)	39302
128	Бусад биег бус хөрөнгө	6,736,000.00	6,736,000.00	39303

136	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,855,847,856.89	1,858,687,917.99	3
137	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	(0.00)	756,000.00	4
138	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	(0.00)	756,000.00	41
163	Өглөг	(0.00)	756,000.00	413
164	Ажиллагчидтай холбогдсон өглөг	(0.00)	-	41310
169	Бусад өглөг	0.00	756,000.00	4136
170	Байгууллагад төлөх өглөг	0.00	756,000.00	41361
213	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,855,847,856.89	1,857,931,917.99	5
214	Засгийн газрын хувь оролцоо	1,855,847,856.88	1,857,931,917.98	51
215	Засгийн газрын оруулсан капитал /ЗГ Сан/ орон нутгийн сан	60,133,555.30	60,133,555.30	511
216	Өмч: -Төрийн өмч	60,133,555.30	60,133,555.30	51101
222	Хуримтлагдсан үр дүн	1,690,665,903.88	1,692,749,964.98	512
223	Өмнөх үеийн үр дүн	1,690,665,903.88	1,690,665,903.88	51210
224	Тайлант үеийн үр дүн	-	2,084,061.10	51220
226	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	105,048,397.71	105,048,397.71	51300
230	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,855,847,856.89	1,858,687,917.99	6

2. 2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

SORT_ID	ITEM_NAME	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ	ДАНС
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	435,015,055.92	544,575,280.00	1
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,291,555.92	35,898,480.00	12
77	Нийтлэг татварын бус орлого	23,291,555.92	35,898,480.00	120
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	23,291,555.92	35,898,480.00	120004
83	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,000,000.00	2,400,000.00	1200042
86	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	16,291,555.92	33,498,480.00	1200045
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	62,465,000.00	72,472,400.00	13
118	Тусгай зорцуулалтын шилжүүлгээс санхүүжих	349,258,500.00	436,204,400.00	131007
128	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,315,000.00	72,472,400.00	1320
129	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	62,315,000.00	72,472,400.00	132001
136	Төсвийн захирагчдаас	150,000.00	-	1330
137	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	150,000.00	-	133001
146	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	427,258,040.31	542,491,218.90	2
147	УРСГАЛ ЗАРДАЛ	427,258,040.31	542,491,218.90	21
148	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	427,003,498.48	542,357,897.43	210
149	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	258,274,018.67	361,310,031.15	2101
150	Цалин	192,220,696.97	239,168,198.50	210101
151	Нэмэгдэл цалин	54,171,458.25	111,560,982.65	210102
153	Урамшуулал	11,881,863.45	10,580,850.00	210104
156	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,161,681.92	46,369,524.88	2102
157	Тэтгэврийн даатгалын шимтгэл	21,887,914.31	31,300,489.38	210201

158	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,575,048.72	3,671,989.91	210202
159	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,055,638.99	2,100,290.83	210203
160	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	503,982.38	1,830,467.02	210204
161	Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,139,097.52	7,466,287.74	210205
163	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,306,458.17	71,535,738.53	2103
164	Гэрэл цахилгааны зардал	3,402,189.17	3,335,838.53	210301
165	Түлш, халаалтын зардал	57,904,269.00	68,199,900.00	210302
169	Хангамж, бараа материалын зардал	5,931,515.00	5,690,530.00	2104
170	Бичиг хэргийн материал	1,972,300.00	2,835,100.00	210401
171	Тээвэр, шатахууны зардал	1,785,965.00	1,582,000.00	210402
176	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,173,250.00	1,273,430.00	210407
180	Нормативт зардал	23,649,850.00	26,777,076.75	2105
181	Эм	26,000.00	51,500.00	210501
182	Хоол	23,623,850.00	26,725,576.75	210502
184	Эд хогшил, урсгал засварын зардал	1,300,000.00	634,000.00	2106
188	Урсгал засвар	1,300,000.00	634,000.00	210604
193	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	540,000.00	627,500.00	2108
199	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	540,000.00	627,500.00	210806
208	Бараа үйлчилгээний бусад зардал	43,839,974.72	29,413,496.12	2109
209	Бараа үйлчилгээний бусад зардал	3,284,967.00	2,476,000.00	210901
210	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	190,000.00	-	210902
211	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	40,365,007.72	26,937,496.12	210903
223	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	254,541.83	133,321.47	213
241	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	254,541.83	133,321.47	2134
244	Төвлөрүүлэх шилжүүлэг	254,541.83	133,321.47	213403
267	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III-I-II)	7,757,015.61	2,084,061.10	3
287	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	7,757,015.61	2,084,061.10	7

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

ДАНС	ITEM NAME	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	418,723,500.00	511,076,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,000,000.00	2,400,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,000,000.00	2,400,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	7,000,000.00	2,400,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,000,000.00	2,400,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	411,723,500.00	508,676,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	349,258,500.00	436,204,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,315,000.00	72,472,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	62,315,000.00	72,472,400.00
1330	Төсвийн захирагчдаас	150,000.00	-
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	150,000.00	-

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	382,530,658.99	516,637,140.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	382,530,658.99	516,637,140.21
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	382,276,117.16	516,503,818.74
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	257,091,860.07	362,590,799.21
210101	Үндсэн цалин	168,678,309.88	223,283,990.31
210102	Нэмэгдэл	76,149,786.74	124,637,685.40
210104	Үр дүнгийн урамшуулал	12,263,763.45	14,669,123.50
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	32,161,681.92	45,323,391.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	19,287,981.92	30,820,200.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,218,000.00	3,625,891.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,574,000.00	1,813,000.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	643,000.00	1,806,400.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	6,438,700.00	7,257,900.00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	61,060,458.17	71,339,659.05
210301	Гэрэл цахилгааны зардал	2,138,000.00	2,000,000.00
210302	Түши, халаалтын зардал	57,904,269.00	68,199,900.00
210303	Цэвэр, бохир усны зардал	1,018,189.17	1,139,759.05
2105	Нормативт зардал	20,902,550.00	24,288,150.00
210502	Хоол, хүнс	20,902,550.00	24,288,150.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	999,419.48
210604	Урсгал засвар	1,000,000.00	999,419.48
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	540,000.00	627,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	540,000.00	627,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,519,567.00	11,334,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,871,967.00	8,163,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	1,647,600.00	3,171,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	254,541.83	133,321.47
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	254,541.83	133,321.47
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	254,541.83	133,321.47
3	ҮЙЛ АЖИЛЛАГА ААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	36,192,841.01	(5,560,340.21)
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГА ААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	7,000,000.00	600,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,000,000.00	600,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,000,000.00	600,000.00
225102	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал /ТӨҮТ/	7,000,000.00	600,000.00

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(7,000,000.00)	(600,000.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	29,192,841.01	(6,160,340.21)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,194,005.13	37,386,846.14
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	37,386,846.14	31,226,505.93

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
0	ДАНС	511	51300	51210+51220	
2	2023 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	53,397,555.30	14,398,151.28	(28,532,033.04)	39,263,673.54
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	53,397,555.30	14,398,151.28	(28,532,033.04)	39,263,673.54
5	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	-	-	-
6	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-	-
7	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
8	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	(523,188.73)	(523,188.73)
9	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	60,133,555.30	105,048,397.70	1,690,665,903.88	1,855,847,856.88
10	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	60,133,555.30	105,048,397.70	1,690,665,903.88	1,855,847,856.88
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	60,133,555.30	105,048,397.70	1,690,665,903.88	1,855,847,856.88
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
16	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	2,084,061.10	2,084,061.10
17	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	60,133,555.30	105,048,397.71	1,692,749,964.99	1,857,931,917.98

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 сарын 31

/төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	37,386,846.14	(37,386,846.14)	-
	ХӨТӨЛБӨР 71801	-	-	-	-
	АРГА ХЭМЖЭЭ 81807	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	26,919,600.00	24,288,150.00	2,631,450.00	90.22
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	26,919,600.00	24,288,150.00	2,631,450.00	90.22
210	Бараа, үйлчилгээний зардал	26,919,600.00	24,288,150.00	2,631,450.00	90.22
2105	Нормативт зардал	26,919,600.00	24,288,150.00	2,631,450.00	90.22
210502	Хоол, хүнс	26,919,600.00	24,288,150.00	2,631,450.00	90.22
	ХӨТӨЛБӨР 71801	-	-	-	-
	АРГА ХЭМЖЭЭ 81816	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,947,700.00	1,910,000.00	37,700.00	98.06
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,947,700.00	1,910,000.00	37,700.00	98.06
210	Бараа, үйлчилгээний зардал	1,947,700.00	1,910,000.00	37,700.00	98.06
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	1,947,700.00	1,910,000.00	37,700.00	98.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,947,700.00	1,910,000.00	37,700.00	98.06
	ХӨТӨЛБӨР 71801	-	-	-	-
	АРГА ХЭМЖЭЭ 81834	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	437,986,300.00	412,843,890.21	25,142,409.79	94.26
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	437,986,300.00	412,843,890.21	25,142,409.79	94.26
210	Бараа, үйлчилгээний зардал	437,986,300.00	412,843,890.21	25,142,409.79	94.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	383,485,600.00	358,391,999.21	25,093,600.79	93.46
210101	Үндсэн цалин	252,853,600.00	223,283,990.31	29,569,609.69	88.31
210102	Нэмэгдэл	127,101,700.00	124,637,685.40	2,464,014.60	98.06
210104	Урамшуулал	3,530,300.00	10,470,323.50	(6,940,023.50)	296.58
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,807,600.00	44,798,991.00	1,008,609.00	97.80
210201	Тэтгэврийн даатгал	31,149,700.00	30,463,300.00	686,400.00	97.80
210202	Тэтгэмжийн даатгал	3,664,100.00	3,583,891.00	80,209.00	97.81
210203	ҮОМШӨ ний даатгал	1,832,300.00	1,792,000.00	40,300.00	97.80
210204	Ажилгүйдлийн даатгал	1,832,300.00	1,792,000.00	40,300.00	97.80
210205	Эрүүл мэндийн даатгал	7,329,200.00	7,167,800.00	161,400.00	97.80
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	999,100.00	627,500.00	371,600.00	62.81
210806	Мэдээллийн технологийн зардал	999,100.00	627,500.00	371,600.00	62.81
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	7,694,000.00	9,025,400.00	(1,331,400.00)	117.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,520,800.00	5,854,200.00	(1,333,400.00)	129.49

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,173,200.00	3,171,200.00	2,000.00	99.94
	ХӨТӨЛБӨР 71801	-	-	-	-
	АРГА ХЭМЖЭЭ 81835	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,723,700.00	4,723,200.00	500.00	99.99
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	4,723,700.00	4,723,200.00	500.00	99.99
210	Бараа, үйлчилгээний зардал	4,723,700.00	4,723,200.00	500.00	99.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,198,800.00	4,198,800.00	-	100.00
210104	Урамшуулал	4,198,800.00	4,198,800.00	-	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	524,900.00	524,400.00	500.00	99.90
210201	Тэтгэврийн даатгал	356,900.00	356,900.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	42,000.00	42,000.00	-	100.00
210203	ҮОМШӨ ний даатгал	21,000.00	21,000.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	21,000.00	14,400.00	6,600.00	68.57
210205	Эрүүл мэндийн даатгал	84,000.00	90,100.00	(6,100.00)	107.26
	ХӨТӨЛБӨР 71801	-	-	-	-
	АРГА ХЭМЖЭЭ 83603	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,400,000.00	599,500.00	1,800,500.00	24.98
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,400,000.00	599,500.00	1,800,500.00	24.98
210	Бараа, үйлчилгээний зардал	2,400,000.00	599,500.00	1,800,500.00	24.98
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	2,400,000.00	599,500.00	1,800,500.00	24.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,400,000.00	599,500.00	1,800,500.00	24.98
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	446,072,800.00	438,604,400.00	7,468,400.00	98.33
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	443,672,800.00	436,204,400.00	7,468,400.00	98.32
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	443,672,800.00	436,204,400.00	7,468,400.00	98.32
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,400,000.00	2,400,000.00	-	100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,400,000.00	2,400,000.00	-	100.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	37,386,846.14	(37,386,846.14)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	31,226,505.93	(31,226,505.93)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	16.00	16.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	4.00	4.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8.00	-	100.00
620004	Гэрээт ажилтан	3.00	3.00	-	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	136.00	136.00	-	100.00

631	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага	136.00	136.00	-	100.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	136.00	136.00	-	100.00
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-	-	-
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	16.00	16.00	-	100.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч /ТҮБД/	9.00	9.00	-	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ТҮ/	4.00	4.00	-	100.00
650010	Гэрээт ажилтан	3.00	3.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 сарын 31

/төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
2	I. Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	72,472,400.00	72,339,078.53	133,321.47	99.82
21	Урсгал зардлын дүн	72,472,400.00	72,339,078.53	133,321.47	99.82
210	Бараа, үйлчилгээний зардал	72,472,400.00	72,339,078.53	133,321.47	99.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71,472,400.00	71,339,659.05	132,740.95	99.81
210301	Гэрэл цахилгаан	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
210302	Түлш, халаалт	68,199,900.00	68,199,900.00	-	100.00
210303	Цэвэр, бохир ус	1,272,500.00	1,139,759.05	132,740.95	89.57
2106	Эд хогшил худалдан авах	1,000,000.00	999,419.48	580.52	99.94
210604	Урсгал засвар	1,000,000.00	999,419.48	580.52	99.94
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	72,472,400.00	72,472,400.00	-	100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	72,472,400.00	72,472,400.00	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	72,472,400.00	72,472,400.00	-	100.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Завхан аймгийн Цэцэн-Уул сумын хүүхдийн цэцэрлэгийн чиглэл:

Цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын зорилго, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, хүүхдийг асрах, хамгаалах, тэдний хөгжил, төлөвшлийг дэмжсэн цогц үйл ажиллагаа эрхэлнэ.

Завхан аймгийн Цэцэн-Уул сумын хүүхдийн цэцэрлэгийн зорилго:

Завхан аймгийн Цэцэн-Уул сумын хүүхдийн цэцэрлэг нь бага насны хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийг дэмжиж, сургуульд бэлтгэх, суралцагчийг бие даан

сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж, ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэх зорилготой үйл ажиллагаагаа явуулж байгаа Боловсрол Шинжлэх Ухааны яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 69 арга хэмжээ төлөвлөснөөс 95 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Завхан аймгийн Цэцэн-Уул сумын хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
2. Боловсролын ерөнхий хууль
3. Төрийн хэмнэлтийн тухай хууль
4. Төрийн албаны тухай хууль
5. Төсвийн тухай хууль
6. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
7. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
8. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
9. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
10. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
11. Хөдөлмөрийн тухай хууль
12. Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй бөгөөд "төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэх тухай", "орон нутагт ажилласны нэмэгдлийг тооцож олгох тухай", "цэцэрлэгийн хүүхдийн хоолны нэг өдрийн зардлын хэмжээг нэмэгдүүлэх" зэрэг Засгийн газрын тогтоолуудад өөрчлөлт орсон байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Тус цэцэрлэг нь дотоод хяналтын нэгжгүй бөгөөд Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд байгууллагын дарга, санхүүгийн ажилтан төрийн сангийн мэргэжилтэн нар хяналт тавин ажиллаж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголто олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан аймгийн Цэцэн-Уул сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Завхан аймгийн Цэцэн-Уул сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос мянган төгрөгөөр буюу хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	85,414.9	88,244.0	2,829.1
Авлага	240.8	475.4	234.6
Бараа материал	47,787.3	56,542.1	8,754.8
Үндсэн хөрөнгө	1770432.8	1770443.8	0
Нийт хөрөнгө	1855847.8	1858687.9	
Өр төлбөрийн дүн	0	756.0	-756.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1855847.8	1857931.9	2,084.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1855847.8	1858687.9	2,840.0

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант онд:

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл өмнөх оноос 2,829.1 мянган төгрөгөөр, бараа материал 8,754.8 мянган төгрөгөөр, авлага 234.6 мянган төгрөгөөр, өглөг 756.0 мянган төгрөгөөр тус тус өсчээ.

Тус цэцэрлэг нь оны эхэнд 47,787.3 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант онд төсвийн хөрөнгөөр 34,706.4 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч 7,150.0 мянган төгрөгийн бусад хангамжийн материал хандив тусламжаар хүлээн авч, 33,101.6 мянган төгрөгийн зарцуулалт хийснээр 56,542.1 мянган төгрөгийн бараа материалыг тоолж, тооллогын бүртгэл хөтөлж, тооцоог бодсон байна. Үндсэн хөрөнгийн хувьд 600.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, 26,348.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг хандив тусламжаар орлогот авч бүртгэлд тусгажээ. Тайлант онд 26,937.5 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон байна.

Тайлант оны эцэст авлага өмнөх оноос 234.6 мянган төгрөгөөр, өглөг 756.0 мянган төгрөгөөр тус тус өсч өглөг, авлага бууруулах, барагдуулах ажил зохион байгуулаагүй байна.

Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Засгийн газрын 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар батлагдсан "төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэх тухай", "орон нутагт ажилласны нэмэгдлийг тооцож олгох тухай" 82, 128 дугаар тогтоолуудын дагуу ажилчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл нэмэгдэж, төсвийг тодотгосноор тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс

548,596.9 мянган төгрөгөөр, зардлыг 546,596.9 мянган төгрөг байхаар тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн, батлуулж ажилласан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээнд улсын болон орон нутгийн төсвөөс 508,676.8 мянган төгрөгийг олгосон бол туслах үйл ажиллагааны орлогоос 2,400.0 мянган төгрөгийг төвлөрүүлэн зарцуулжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 517,237.1 мянган төгрөг буюу 99.73 хувьтай байна. Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, хоолны зардал, бараа үйлчилгээний бусад зардлуудыг 2,520.6 мянган төгрөгөөс 25,093.6 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>					
Хөтөлбөрг ага хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Улсын төсвөөс санхүүжих					
71801	Сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөр	477,124.5	444,897.7	31,226.5	93.75
81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардал	26,919.6	24,288.1	2,631.4	90.22
81816	Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	1,947.7	1,910.0	37.7	98.06
81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал	437,986.3	412,843.9	25,142.4	94.26
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	4,723.7	4,723.2	0.5	99.99
83603		2,400.0	599.5	1,800.5	24.98
Дүн		477,124.5	444,897.7	31,226.5	93.75
Орон нутгийн төсвөөс санхүүжих					
80109	Тогтмол зардал	72,472.4	72,339.4	133.3	99.82
Нийт дүн		548,596.9	517,237.1	31,359.8	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 72,472.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, байр ашиглалттай холбоотой зардалд 71,339.7 мянган төгрөг, урсгал засварын зардалд 999.4 мянган төгрөгийг зарцуулж, 133.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл

8 иргэн болон Цэцэн тэгш хоршоо, нийт 9 гэрээ /шууд аргаар/	Хоол хүнс	26,919.6	24,288.1
Ти ЖИ Өү ЖИ ХХК шууд гэрээ	Халаалт, дулаан	68,199.9	68,199.9
ДҮН		95,119.5	92,488.0

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Завхан аймгийн Цэцэн-Уул сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан соёмбо аудит ХХК-ний аудитор Р.Мядагмаа хийж, анхан шатны хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсувд, аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн Цэцэн-Уул сумын хүүхдийн цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 1.5 хувиар тооцож, 5,737.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75.0 хувь буюу 4,303.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлын хувь хэмжээг 2024 оны орлого үр дүнгийн тайлангийн 544,575.0 мянган төгрөгнөөс 1.5%-иар тооцож 8,168.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлын хувийг 75.0%-иар 6,126.4 мянган төгрөгөөр үзүүлэлтийг шийнчлэн тогтоосон

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, гүйцэтгэлийн үе шатанд материаллаг түвшинг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 5 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завхан аймгийн Цэцэн-Уул сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан тул акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Авлагын насжилтаараа 10 гаруй жил болсон 120,8 мянган төгрөгийн авлагыг барагдуулах ажил зохион байгуулах

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар гэрчилгээтэй газрыг данс бүртгэлд аваагүй зөрчил илэрсэнд зөвлөмж өгөв.

5.1 Төлбөрийн акт: тогтоогоогүй

5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй

5.3 Зөвлөмж:

1. Хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илэрүүлэлт: 1. 000010041 дугаар бүхий 929 м.кв газрыг бүртгэлд аваагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71.1.1-д "Үндсэн хөрөнгөд гарсан хөдөлгөөн,

өөрчлөлтийг нягтлан бодохын дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан байх, техник, технологийн баримт бичгийг гүйцэд бүрдүүлсэн байх"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4.-д "Үнэн зөв байх" зэрэг заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газрын хэмжээ, үнэлгээг хянаж, бүртгэлд бүрэн тусгах .

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингөөс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.


Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИПЭРСЭН БУРУУ ИПЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
000010041 дугаар бүхий 929 м.кв газрыг бүртгэлд аваагүй байна.	1	0					1	0				
Дүн	1	0					1	0				

АУДИТЫН ТАЙЛАНГ:



ХЯНАСАН:
 АХЛАХ АУДИТОР
 АУДИТЫН МЕНЕЖЕР
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

БОЛОВСРУУЛСАН:

“ХААН СОЁМБО АУДИТ” ХХК-НИЙ АУДИТОР

[Handwritten signature]

Р.МЯДАГМАА

Огноо: 2025-02-24